



ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/01

Улаанбаатар хот  
2012 он



## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуйн салбар	2
2. Аж үйлдвэрийн салбар	6
3. Хүнсний үйлдвэрийн салбар	8
4. Цаг агаар	10

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Том малын зүй бус хорогдол 2012 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 22.8 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 41.7 мян. толгой буюу 64.6 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр авч үзвэл адуу 1.5 мянга, үхэр 2.2 мянга, хонь 9.2 мянга, ямаа 9.8 мянга байна. Нийт хорогдсон малын 43.2 хувийг ямаа, 40.2 хувийг хонь эзэлж байна.




2012 оны 1 дүгээр сард Архангай аймагт оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь буюу 4.7 мянга, Ховд аймагт 0.2 хувь буюу 3.5 мянга, Увс аймагт 0.1 хувь буюу 2.5 мянга, Баянхонгор аймагт 0.1 хувь буюу 1.9 мянга, Дорнод аймагт 0.1 хувь буюу 1.5 мянга нь хорогдлоо. Улсын хэмжээнд хорогдсон малын 61.9 хувийг эдгээр аймагт хорогдсон мал эзэлж байна.

Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2012 оны 1 дүгээр сард 0.9 мян.толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 0.2 мян.толгой буюу 18.2 хувиар бага байна.

### *Зүй бусаар хорогдсон том мал /жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар/*

Төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 <sup>I</sup>	2011 <sup>I</sup>	2012 <sup>I</sup>	2010 <sup>I</sup>	2011 <sup>I</sup>	2012 <sup>I</sup>
<b>Бүгд</b>	<b>1860.5</b>	<b>64.5</b>	<b>22.8</b>	<b>4.2</b>	<b>0.2</b>	<b>0.1</b>
Тэмээ	0.7	0.1	0.0	0.3	0.0	0.0
Адуу	54.2	2.3	1.5	2.4	0.1	0.1
Үхэр	107.7	5.2	2.2	4.1	0.2	0.1
Хонь	635.6	22.2	9.2	3.3	0.2	0.1
Ямаа	1062.3	34.7	9.8	5.4	0.2	0.1

### *Зүй бусаар хорогдсон том мал, мян.тол*





**ХӨДӨӨ АЖ АХҮЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ**

Аймаг, нийслэл	төг.					
	Үхрийн шир, ширхэг					
	2 м-ээс доош урттай			2 м-ээс дээш урттай		
	2011.I	2011.XII	2012.I	2011.I	2011.XII	2012.I
<b>Баруун бүс</b>						
Баян-Өлгий	11000	21500	22500	-	25000	27000
Говь-Алтай	7500	-	-	10000	27000	28000
Завхан	13000	25000	27800	15000	35000	35000
Увс	13000	20000	28000	15000	25000	30000
Ховд	15000	-	-	18000	26000	27000
<b>Хангайн бүс</b>						
Архангай	15000	29000	31000	25000	38000	38000
Баянхонгор	13000	25000	25000	-	28000	30000
Булган	12000	27500	31000	21000	36000	37500
Орхон	12500	26500	31000	18000	37500	40000
Өвөрхангай	-	-	-	12000	25000	30000
Хөвсгөл	15000	27000	25000	20000	35000	30000
<b>Төвийн бүс</b>						
Говьсүмбэр	-	28000	25000	-	30000	30000
Дархан-Уул	9500	29000	29000	23000	36000	36000
Дорноговь	-	-	20000	14000	-	30000
Дундговь	14000	-	-	18500	29000	28700
Өмнөговь	-	-	20000	-	20000	-
Сэлэнгэ	13000	25000	28000	24000	35000	38000
Төв	9000	24000	30000	17500	40000	40000
<b>Зүүн бүс</b>						
Дорнод	10500	25000	30000	15500	28300	35000
Сүхбаатар	13500	25000	30000	20000	35000	36500
Хэнтий	15000	28000	32000	-	-	-
<b>Улаанбаатар</b>						
Улаанбаатар	15500	30000	35000	26000	40000	41000
<b>төг.</b>						
Аймаг, нийслэл	2011.I			2012.I		
	Адууны шир, ширхэг					
	<b>Баруун бүс</b>					
Баян-Өлгий	18000			41000		
Говь-Алтай	20000			39000		
Завхан	21500			35000		
Увс	20000			35000		



Ховд	20000	38000	40000
	<b>Хангайн бүс</b>		
Архангай	25000	38000	40000
Баянхонгор	23000	38000	40000
Булган	18500	40500	40500
Орхон	20000	25000	41000
Өвөрхангай	26000	38000	40000
Хөвсгөл	25000	30000	42000
	<b>Төвийн бүс</b>		
Говьсүмбэр	-	35000	39000
Дархан-Уул	25000	32000	32000
Дорноговь	22000	40000	41000
Дундговь	25500	43000	42300
Өмнөговь	21000	32000	35000
Сэлэнгэ	20000	31500	32000
Төв	24000	35500	44000
	<b>Зүүн бүс</b>		
Дорнод	20000	38000	42000
Сүхбаатар	23000	40000	45000
Хэнтий	25000	43000	45000
	<b>Улаанбаатар</b>		
Улаанбаатар	24000	39000	42000

төг.

Аймаг, нийслэл	Ямааны ноолуур, кг					
	2011.I	Цагаан 2011.XII	2012.I	2011.I	Бор 2011. XII	2012.I
	<b>Баруун бүс</b>					
Баян-Өлгий	-	48000	50000	40000	48000	50000
Говь-Алтай	45000	45000	45300	45000	45000	45300
Завхан	45000	45000	45000	-	45000	45000
Ховд	45000	50000	-	-	50000	-
	<b>Хангайн бүс</b>					
Архангай	40000	45000	55000	40000	45000	55000
Баянхонгор	48000	45000	45000	48000	40000	-
Орхон	43000	49000	51000	40500	49000	50000
Өвөрхангай	49000	46000	47000	49000	46000	47000
Хөвсгөл	48000	45000	63000	50000	42000	52000
	<b>Төвийн бүс</b>					
Говьсүмбэр	45000	-	-	-	-	-
Дархан-Уул	40000	45000	40000	40000	45000	40000
Дорноговь	45000	45000	45000	45000	43000	45000
Дундговь	-	49000	45000	41000	-	-
Өмнөговь	48000	40000	46000	48000	-	46000



Сэлэнгэ	40000	-	-	40000	-	-
Төв	44000	-	50000	44500	-	50000
<b>Зүүн бүс</b>						
Сүхбаатар	42500	-	-	-	-	-
Хэнтий	35000	-	-	-	-	-
<b>Улаанбаатар</b>						
Улаанбаатар	45000	50000	47000	45000	-	-

төг.

Аймаг, нийслэл	1 ширхэгийн дундаж үнэ					
	Хонины /ноостой/ нэхий, ширхэг			Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг		
	2011.I	2011.XII	2012.I	2011.I	2011. XII	2012.I
<b>Баруун бүс</b>						
Баян-Өлгий	6000	14300	14800	17000	20300	21800
Говь-Алтай	8300	-	19000	19000	22200	23000
Завхан	5000	18000	19000	18000	19700	21000
Увс	6000	13500	-	18000	19500	20000
Ховд	7500	19500	15000	20000	21500	20000
<b>Хангайн бүс</b>						
Архангай	9000	19000	19000	20000	19000	21000
Баянхонгор	8000	19000	20000	18000	21500	27000
Булган	7000	17000	18000	15000	18500	21000
Орхон	8000	13000	19000	16500	-	-
Өвөрхангай	8500	20000	20000	20000	22000	23000
Хөвсгөл	8000	17000	19000	15000	-	21000
<b>Төвийн бүс</b>						
Говьсүмбэр	7500	15000	18500	19000	18000	22000
Дархан-Уул	9000	17000	19000	-	21000	23000
Дорноговь	8000	18000	19000	17000	20000	22000
Дундговь	8500	20000	20000	21000	23700	25000
Өмнөговь	7000	16000	19000	17000	22000	24000
Сэлэнгэ	5000	-	18000	-	-	20000
Төв	7500	16300	-	-	19000	25000
<b>Зүүн бүс</b>						
Дорнод	5200	12000	-	15800	18000	21300
Сүхбаатар	5000	14000	17000	15000	20000	24000
Хэнтий	7000	14000	17000	18000	22000	25000
<b>Улаанбаатар</b>						
Улаанбаатар	7000	14000	16000	18500	17000	20000

### 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны 1 дүгээр сард 154.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 тэрбум төг буюу 5.7 хувиар өслөө.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг.**

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2010.I</i>	<i>2011.I</i>	<i>2012.I</i>	<i><math>\frac{2012.I}{2011.I} \%</math></i>
Нийт дүн	142558.3	146467.5	154756.5	105.7
Боловсруулах аж үйлдвэр	41733.9	41691.9	42170.6	101.1
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	26811.0	26933.3	27353.7	101.6
Тамхи үйлдвэрлэл	81.2	2175.8	1313.0	60.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	4501.8	4825.9	4135.3	85.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	626.4	748.3	517.6	69.2
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	47.1	38.7	106.1	274.3
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	133.3	179.3	148.0	82.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	173.3	162.1	245.2	151.3
Тавилга үйлдвэрлэл, бусад	57.8	97.9	75.8	77.4

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, оны үнээр, сая төг.**

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2010.I</i>	<i>2011.I</i>	<i>2012.I</i>	<i>Үүнээс: гадаадад</i>
<b>Аж үйлдвэр, бүгд</b>	<b>281946.4</b>	<b>291545.1</b>	<b>355424.8</b>	<b>183659.6</b>
<b>Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн</b>	<b>185256.0</b>	<b>175946.3</b>	<b>202923.5</b>	<b>172056.6</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	39526.3	53040.7	70297.0	317.0
Тамхи үйлдвэрлэл	2011.4	3500.0	3414.0	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	5409.3	7059.7	5144.1	772.3

Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	757.2	973.6	1078.6	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	98.3	60.9	86.0	-
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	322.8	599.2	628.6	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	904.1	1089.7	772.0	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	56.5	48.6	96.8	-

*Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт*

<i>Бүтээгдэхүүн</i>	<i>хэм.нэгж</i>	<i>2010.I</i>	<i>2011.I</i>	<i>2012.I</i>	<i><math>\frac{2012.I}{2011.I} \%</math></i>
Хивс	мян.м <sup>2</sup>	56.0	70.0	84.9	121.3
Сүлжмэл эдлэл	мян.ш	38.6	55.8	45.0	80.6
Самнасан ноолуур	т	19.5	4.3	7.2	167.4
Эсгий	мян.м	7.9	8.1	7.1	87.7
Тэмээний ноосон хөнжил	мян.м	1.2	2.4	1.7	70.8
Эсгий гутал	мян.хос	2.5	3.4	2.2	65.8
Нэхий дээл	ш	2100	2630	1441	54.8
Савхин гутал, ботинк	мян.хос	1.4	0.6	1.0	178.5
Барилгын модон хаалга, цонх	м <sup>2</sup>	209.1	749.5	332.6	44.4
Барилгын шалны банз	м <sup>3</sup>	70.0	-	111.7	-
Зүсмэл материал	м <sup>3</sup>	375.7	203.8	290.4	142.5
Дэвтэр	мян.ш	471.4	556.8	1013.7	182.1
Ариун цэврийн цаас	мян.ш	122.9	125.3	114.5	91.4
Сонины цаас	т	12.4	-	-	-
Бичгийн цаас	т	17.2	23.8	-	-
Сонин	сая.х.д.х	3.0	3.0	4.3	144.5
Ном	сая.х.д.х	4.0	3.1	3.0	98.1



#### 4.ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2010.I	2011.I	2012.I	$\frac{2012.I\%}{2011.I}$
<b>Мах, махан бүтээгдэхүүн</b>					
Үхрийн мах	т	104.6	112.6	436.1	387.3
Хонины мах	т	839.7	171.5	409.9	239.0
Адууны мах	т	15.0	52.4	16.2	32.1
Ямааны мах	т	228.5	52.1	296.3	568.7
Гахайн мах	т	0.8	0.9	1.7	188.9
Өлөн гэдэс	мян.гогцоо	109.8	76.9	59.7	77.6
Хиамны зүйл	т	98.6	184.6	137.9	74.4
<b>Сүү, сүүн бүтээгдэхүүн</b>					
Боловруулсан шингэн сүү	мян.л	1170.3	2431.1	2299.5	94.6
Тараг	мян.л	394.6	518.5	484.4	93.4
Цөцгий, цөцгийн тос	т	65.7	61.8	164.6	266.3
Аарц, бяслаг	т	19.0	18.3	7.8	42.6
<b>Гурил, гурилан бүтээгдэхүүн</b>					
Дээд гурил	т	9511.3	5096.3	2098.7	41.2
Нэгдүгээр гурил	т	11978.1	10115.4	5572.4	55.1
Хоёрдугаар гурил	т	1261.6	783.6	521.7	66.6
Малын тэжээл	т	10475.7	5521.1	2672.8	48.4
Нарийн боов	т	1309.8	1411.1	1481.5	105.0
Бялуу	т	17.0	27.1	29.1	107.4
Чихэр	т	15.5	12.2	11.6	95.1
Талх	т	1829.6	1610.2	2229.7	138.5
Гоймон	т	725.5	92.4	260.8	282.3
<b>Согтууруулах болон согтууруулах бус ундаа</b>					
Спирт	мян.л	449.9	565.1	380.6	67.4
Архи	мян.л	1866.2	2776.5	2642.8	95.2
Дарс	мян.л	20.4	7.3	5.7	78.1
Шар айраг	мян.л	3087.4	4114.5	5078.7	123.4
Цэвэр ус	мян.л	1680.9	1328.9	2013.5	151.5
Амтат ус, ундаа	мян.л	2304.8	2243.2	3532.9	157.5
Жүүс	мян.л	1574.9	2460.4	4245.4	172.5

### Экспортын гол нэрийн бараа

<i>Бараа</i>	<i>хэм.нэгж</i>	<b>2011.1</b>	<b>2012.1</b>	<b><u>2012.1%</u> <u>2011.1</u></b>
Малын дайвар бүтээгдэхүүн	т	24.4	328.8	1349.5
Шеврет	сая дм <sup>2</sup>	17.3	26.0	150.1
Шевро	сая дм <sup>2</sup>	2.4	8.6	359.4
Адууны шир	мян.ш	59.5	17.8	29.9
Хонины самнаагүй ноос	т	1438.1	84.0	5.8
Бохир ноолуур	т	-	13.8	-
Самнасан ноолуур	т	6.4	0.5	7.9
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	0.4	0.3	79.9


### Импортын гол нэрийн бараа

<i>Бараа</i>	<i>хэм.нэгж</i>	<b>2011.1</b>	<b>2012.1</b>	<b><u>2012.1%</u> <u>2011.1</u></b>
Өндөг	мян.ш	6137.8	4505.4	73.4
Төмс	т	18.9	6.8	36.0
Сонгино, сармис	т	711.5	883.5	124.2
Алим, лийр	т	453.3	178.4	39.4
Ногоон цай	т	236.4	372.5	157.6
Цагаан будаа	т	1025.4	352.0	34.3
Гурил	мян.т	4.6	9.0	193.2
Ургамлын тос	т	276.4	479.4	173.5
Элсэн чихэр	т	5037.5	3883.4	76.5
Хатуу чихэр	т	730.6	663.4	90.8
Согтууруулах биш ундаа	мян.л	172.0	245.1	142.5
Согтууруулах ундаа	мян.л	568.7	1708.0	300.3
Янжуур	сая.ш	149.0	138.7	93.1

## ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ\*\*

### (III сар)

**Баруун зүгийн нутаг.** Энэ сарын агаарын дундаж температур нь нутгийн хойд хэсгээр 11-16, Алтайн өвөр говиор 0-5 градус, бусад нутгаар 5-10 градус хүйтэн буюу Баян-Өлгийн ихэнх нутаг, Ховдын хойд, Говь-Алтайн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).



Нэгдүгээр арав хоногийн эхний хагас болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр Увс, Завханы хойд хэсгээр шөнөдөө 32-37, өдөртөө 17-22 градус хүйтэн, Алтайн өвөр говиор шөнөдөө 12-17, өдөртөө 3-8 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 21-26, өдөртөө 11-16 градус хүйтэн байна. Гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хагаст өмнөх үеэсээ 4-6 градусаар хүйтэрнэ. Харин гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст харьцангуй дулаарч Увс, Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 15-20 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, Алтайн өвөр говь, Их нууруудын хотгороор шөнөдөө 0-5, өдөртөө 11-16 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Бусад хугацаанд Увс, Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 22-27, өдөртөө 5-10 градус хүйтэн, Алтайн өвөр говиор шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Баян-Өлгийн өмнөд, Увсын зүүн, Завханы хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхээр зарим газраар цас, нэгдүгээр арав хоногийн эцэс, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хагаст, дунд үеэр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон эцсээр Алтайн салбар уулс, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор салхи түр зуур 16 м/с, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд



үеэр зарим газраар 16-18 м/с, Алтайн салбар уулсаар зарим үед 28 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

**Төвийн нутаг.** Энэ сарын агаарын дундаж температур нь Дархадын хотгороор 12-17, бусад нутгаар 6-11 градус хүйтэн байх ба Хөвсгөлийн зүүн, Архангай, Төв аймгийн хойд хэсэг, Булган, Сэлэнгийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр Дархадын хотгор, Орхон-Сэлэнгэ, Хараа, Ерөө голын хөндийгөөр шөнөдөө 24-29, өдөртөө 13-18 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 9-14 градус хүйтэн байна. Мөн гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр өмнөх үеэсээ 4-6 градусаар хүйтэн байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэр бүх нутгаар харьцангуй дулаарч Дархадын хотгороор шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, Архангай, Өвөрхангайн зарим нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна. Бусад хугацаанд Дархадын хотгороор шөнөдөө 18-23, өдөртөө 7-12 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн, Архангай, Өвөрхангайн зарим нутгаар 3-8 градус хүрч дулаарна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хөвсгөл, Төв аймгийн өмнөд хэсэг, Сэлэнгийн хойд, Архангай, Өвөрхангайн ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас ахиу байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим газраар цас, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлийн хагаст зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үеэр зарим газраар 12-14 м/с, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр нутгийн өмнөд хагаст зарим үед 18-20 м/с хүртэл ширүүсч цасан ба шороон шуурга шуурах төлөвтэй.

**Зүүн зүгийн нутаг.** Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар 5-10 градус хүйтэн байх ба Хэнтийн хойд хэсэг, Дорнодын ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхний хагасч Хэрлэн, Халх голын хөндийгөөр шөнөдөө 23-28, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 19-24 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг хүйтэрч Хэрлэн, Халх голын хөндийгөөр 18-23, бусад нутгаар 14-19 градус хүйтэн, өдөртөө бүх нутгаар 1-6 градус хүйтэн байна. Мөн гуравдугаар арав хоногийн сүүлчээр өмнөх үеэсээ 4-6 градусаар хүйтэрнэ. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар харьцангуй дулаарч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө Хэрлэн, Халх голын хөндийгөөр 15-20, бусад нутгаар 11-16 градус хүйтэн, өдөртөө бүх нутгаар 3 градус хүйтнээс 2 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хэнтий, Дорнодын ихэнх нутаг, Сүхбаатарын



зүүн хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе ба эцсээр зарим газраар цас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлийн хагаст ихэнх нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно. Энэ үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр зарим үед 20-24 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

**Говийн нутаг.** Энэ сард агаарын дундаж температур нь Дундговь, Дорноговийн хойд хэсэг, Говь-Сүмбэрийн нутгаар 5-10, бусад нутгаар 0-4 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үеэр шөнөдөө нутгийн хойд хэсгээр 18-23, бусад хэсгээр 14-19 градус хүйтэн, өдөртөө бүх нутгаар 4-9 градус хүйтэн байна. Хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр шөнөдөө 13-18 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус хүйтэн өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч эрс суларч ихэнх нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Дорноговийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр цас, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим нутгаар, харин эцсээр нь нутгийн хойд хэсгээр хур тунадас орно. Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлчээр Арц Богдын өвөр хоолойгоор, хоёрдугаар арав хоногийн дунд үе ба эцэс, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, эцсээр ихэнх нутгаар салхи баруун хойноос 16-18 м/с, зарим үед 24-28 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурах төлөвтэй.

*\*\* - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*